



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 07 сарын 31 өдөр

Дугаар 9/338

Арвайхээр

Өвөлжилтийн бэлтгэл ажлыг
хангах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын "а" дахь заалт, Засгийн газрын 2020 оны "Хөдөө аж ахуйн салбарын 2020-2021 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээ"-ний тухай 19 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Хөдөө аж ахуйн болон төв суурингийн 2020-2021 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг хангах, шалгах, хүлээн авах ажлын хэсгийг нэгдүгээр, хөдөө аж ахуйн болон төв суурингийн 2020-2021 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах нэгдсэн арга хэмжээг хоёрдугаар, аймаг, сумдын аюулгүйн нөөцөд бэлтгэвэл зохих өвс, тэжээлийн хэмжээг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Аймгийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг бүрдүүлэхэд шаардагдах хөрөнгийг тухай бүрт нь шийдвэрлэж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр), Онцгой байдлын газрын дарга (дэд хурандаа Т.Мөнхдорж) нарт үүрэг болгосугай.

3. Хөдөө аж ахуйн болон төв суурингийн өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах төлөвлөгөө гаргаж, хэрэгжүүлэн ажиллахыг Сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Өвөлжилтийн бэлтгэл ажлыг төлөвлөгөөний дагуу сайтар зохион байгуулж, биелэлтийн явц, үр дүнг 2020 оны 10 дугаар сарын 25-ны дотор аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг Ажлын хэсгийн ахлагч (И.Доржсүрэн)-д даалгасугай.

ОРЛОГЧ



О.БАТЖАРГАЛ

011100754

D:My Doc. Zahiramj. Zasag darga